

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/004/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.21 № 01/229  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Г.ЛХАГВАДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн төслийн саналаас Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар Сүмбэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 400,097.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж гүйцэтгэлээр 452,045.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113,0 хувиар биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Сүмбэр сум тайлант онд төв зам дагуух гэрэлтүүлэг 25,000.0 мянган төгрөг, Цэцэрлэгийн гадна талбайн тоглоом 25,887.5 мянган төгрөгөөр, сумын төвийн зам засвар тохижилт хог түрэх ковш 120,000.0 мянган төгрөгөөр, орон нутгийн зам засвар, уулзварын өндөрлөг 85,263.4 мянган төгрөгөөр, мал угаалга ванн болон ариутгалын багаж хэрэгсэл 24,000.0 мянган төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сум 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 43 хөтөлбөр, 177 арга хэмжээг хэрэгжүүлж 96,29 хувьтай дүгнэгдсэн байна. Хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 89,7 хувь байна.

412505359

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>636,415.1</b>	<b>644,366.5</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	112,021.9	197,776.4
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	417,261.2	343,146.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	107,132.1	103,443.6
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>905,496.7</b>	<b>1,708,072.6</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	905,496.7	1,708,072.6
39200	Биет хөрөнгө		892,139.7	1,454,531.6
39300	Биет бус хөрөнгө	13	13,357.0	253,541.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>1,541,911.8</b>	<b>2,352,439.1</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		10,112.7	6,231.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	10,112.7	6,231.5
41300	Өглөг	17а, 17б	10,112.7	6,231.5
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>1,531,799.2</b>	<b>2,346,207.6</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		1,531,799.2	2,346,207.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		372,566.7	372,566.7
51200	Хуримтлагдсан үр дүн		906,683.9	1,721,435.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		252,548.6	252,205.8
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>1,541,911.8</b>	<b>2,352,439.1</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>2,780,204.0</b>	<b>2,847,456.2</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>264,375.5</b>	<b>440,401.8</b>
110	Орлогын албан татвар		198,135.9	357,572.7
1100	Хувь хүний орлогын албан татвар		206,135.9	357,572.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-8,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		42,350.4	49,859.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		23,889.2	32,969.8
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>343,293.7</b>	<b>895,423.6</b>
120	Нийтлэг татварын бус орлого		322,293.7	894,923.6
122	Тусламжийн орлого		21,000.0	500.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>2,172,534.8</b>	<b>1,511,630.8</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>2,664,684.6</b>	<b>2,014,325.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>2,630,628.6</b>	<b>1,986,828.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,518,058.3</b>	<b>1,890,916.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		432,367.8	691,243.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		54,164.2	87,173.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		44,542.1	443,363.0
2104	Хангамж, бараа материалын зардал		300,203.6	332,746.9
2105	Нормативт зардал		86,823.3	79,601.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,982.4	37,406.5
2107	Томилголт, зочны зардал		3,464.3	10,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,693.0	20,512.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		582,817.6	188,869.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>1,112,570.4</b>	<b>95,912.8</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>34,056.0</b>	<b>27,496.5</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>115,519.4</b>	<b>833,130.9</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>177.0</b>	<b>18,722.9</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>115,342.4</b>	<b>814,408.0</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,416,171.2</b>	<b>1,416,171.2</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	343.1	343.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,416,514.2	1,416,514.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-57.4	-57.4
9	Тайлант үеийн үр дүн	115,342.4	115,342.4
10	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,531,799.2</b>	<b>1,531,799.2</b>
11	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,531,799.2</b>	<b>1,531,799.2</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,938.3	-3,938.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,527,860.8	1,527,860.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-342.8	-342.8
19	Тайлант үеийн үр дүн	814,408.0	814,408.0
20	<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>2,346,207.6</b>	<b>2,346,207.6</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,602,203.9</b>	<b>2,124,355.9</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>264,375.5</b>	<b>440,401.8</b>
110	Орлогын албан татвар	198,135.9	357,572.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	206,135.9	357,572.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-8,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	42,350.4	49,859.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	23,889.2	32,969.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,974.7	6,464.6
1181	Газрын төлбөр	17,334.1	24,338.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	580.3	2,167.0
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>165,293.5</b>	<b>172,323.3</b>
120	Нийтлэг татварын бус орлого	144,293.5	171,823.3
122	Тусламжийн орлого	21,000.0	500.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,172,534.8</b>	<b>1,511,630.8</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,211,389.6</b>	<b>1,600,970.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,211,389.6</b>	<b>1,600,970.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,098,819.2</b>	<b>1,504,257.6</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	433,198.5	691,243.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,252.9	87,173.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,012.1	443,363.0
2104	Хангамж, бараа материалын зардал	122,158.2	146,210.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,372.4	47,290.9
2107	Томилолт, зочны зардал	3,764.3	10,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,307.9	17,935.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	435,752.9	61,041.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,112,570.4</b>	<b>96,712.8</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>390,814.3</b>	<b>523,385.6</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>399,622.4</b>	<b>437,481.1</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>399,622.4</b>	<b>437,481.1</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	399,622.4	437,481.1
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-399,622.4</b>	<b>-437,481.1</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-24,353.9</b>	<b>-150.0</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>24,353.9</b>	<b>150.0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-33,162.0</b>	<b>85,754.5</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	145,183.9	112,021.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,021.9	197,776.4

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,869,432.2</b>	<b>1,676,803.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,387,868.8</b>	<b>1,353,688.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,317,886.9</b>	<b>1,286,406.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	639,100.8	612,133.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,325.1	77,680.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	448,205.7	443,228.4
2104	Хангамж, бараа материалын зардал	37,794.0	37,041.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,632.1	44,568.3
2107	Томилолт, зочны зардал	9,740.0	9,490.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,769.0	18,652.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,320.2	43,611.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,981.9</b>	<b>67,281.9</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,981.9	67,281.9
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>381,563.4</b>	<b>322,965.6</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	150.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,869,432.2</b>	<b>1,723,147.4</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>264,263.4</b>	<b>-</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,422,868.8</b>	<b>1,681,233.6</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>162,300.0</b>	<b>41,413.9</b>
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	20,000.0	500.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	17,178.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	63,522.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	54	54
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>156,993.5</b>	<b>231,471.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>106,993.5</b>	<b>206,469.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>83,016.6</b>	<b>172,861.5</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,948.8	77,396.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,145.6	9,312.4
2104	Хангамж, бараа материалын зардал	75.0	5,192.6
2107	Томилолт, зочны зардал	-	510.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	535.0	601.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,312.2	79,848.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,976.9</b>	<b>33,607.8</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	29,346.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,976.9	4,261.5
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>50,000.0</b>	<b>25,002.6</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	50,000.0	25,002.6
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>156,993.5</b>	<b>231,471.9</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	156,993.5	231,471.9
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-</b>	<b>0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 93,340.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

#### Залруулсан алдаа:

1. Орлого, үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого тодруулга тайлантай 93,340.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нийт алдаа, зөрчлөөс 60,099.6 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус, урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 21,031.1 мянган төгрөгөөс бага буюу материаллаг алдаа илрээгүй тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 60,099.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 60,099.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

#### 3.2 Зөвлөмж

##### 1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 39,661.2 мянган төгрөг, аймагт төвлөрүүлэх орлого 10,769.0 мянган төгрөг, орон нутагт төвлөрүүлэх 7 нэр төрлийн орлогыг 9,669.4 мянган төгрөгөөр нийт 60,099.6 мянган төгрөгөөр орлого тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.

##### 2. Шилэн данстай холбоотой асуудал

Тайлант онд тус Засаг дарга шилэн дансны 159 мэдээлэл байршуулахаас 155 мэдээлэл хугацаанд нь, хугацаа хоцроосон 4 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	93,340.5			1	93,340.5	1	93,340.5		
ИТХ	2	680.0	2	19,351.3			2	680.0		
Засаг даргын Тамгын газар	5	1,378,500.4	2	192,230.3	3	1,186,270.1	5	1,378,500.4		
Цэцэрлэг	1	1,474.0	1	1,474.0			1	1,474.0		
ОНХС	1	4,281.4	1	4,281.4			1	4,281.4		
ЭЭС	1	9,866.4			1	9,866.4	1	9,866.4		
ХХС	2	10,397.3	1	4,281.1	1	6,116.2	2	10,397.3		
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>1,498,540.0</b>	<b>7</b>	<b>221618.1</b>	<b>6</b>	<b>1,295,593.2</b>	<b>13</b>	<b>1,498,540.0</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	3	63,034.2	2	2,934.6			1	60,099.6
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	1,575.0			1	1,575.0		
Засаг даргын Тамгын газар	2	11,554.0			1	4,554.0	1	7,000.0
Цэцэрлэг	1	472.1					1	472.1
Хоршоо хөгжүүлэх сан	1	189,790.2					1	189,790.2
Эмийн эргэлтийн сан	3	5,360.4	2	5,360.4	1			
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>271,785.9</b>	<b>4</b>	<b>8,295.0</b>	<b>3</b>	<b>6,129.0</b>	<b>4</b>	<b>257,361.9</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>4</b>		<b>1</b>			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)